



LAVAI-INTERNATIONAL JOURNAL OF EDUCATION

2022 №26, ISSN 2410-4507

Веб сайт: <https://lavai.msue.edu.mn>

Ерөнхий боловсролын сургуулийн VI ангийн сурагчдын сурах ерөнхий 19 үйлийн судалгаа, үр дүн

Шагжжав Ичинхорлоо, Наранцэцэг Мөнхцэцэг*

Монгол улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Боловсролын судлалын сургууль, Боловсрол судлал арга зүйн тэнхим

*Холбоо барих зохиогч: munkhtsetseg.n@msue.edu.mn

Хүлээн авсан: 2021.4.9 Засварласан: 2021.7.21 Хэвлэлтэд авсан: 2021.12.15

Хураангуй

Энэхүү судалгаа нь ЕБС-ийн VI ангийн сурагчдын сурах ерөнхий үйлийн төлөв байдлыг илрүүлж тогтоох зорилготой. Тухайлбал, сурагчийн 1/ном уншихтай холбоотой 4 үйл: уншсан эхээс хэрэгтэй зүйл олж авах, уншсан номын утгыг өөрийн үгээр ярих, номын утгыг эргэцүүлэн бодох, уншсан зүйлийг тэмдэглэх, 2/ ярих үйл: сурагч санаа бодлоо бусдад ойлгомжтой ярих, 3/ сонсох 3 үйл: бусдын яриаг анхааралтай сонсох, бусдын ярианы гол санааг олох, сонссон зүйлд дүгнэлт хийх, 4/ асуулт асуух үйл, 5/ бүтээлч шинжтэй 2 үйл: шинэ санаа дэвшүүлэх, үгийн утгыг өөрийн үгээр тайлбарлах, 6/ хичээл дээр олж мэдсэн зүйлээ өөрийн амьдралд хэрэглэх, 7/ мэдлэг чадвараа хянах 2 үйл: юу шинээр мэдэж авснаа ойлгох, мэдлэг чадварт нь ямар алдаа байгааг олох, 8/ бие даах чадвар, 9/ төлөвшил, хандлагатай холбоотой 4 үйл: бусдад тусалдаг, бусдаас тусламж авдаг, зан байдал, харилцаанд нь байгаа сайн болон болохгүй зүйлийг олох зэрэг ерөнхий үйлийн судалгааг хийснээрээ шинэлэг болно. Судалгааны зарим үр дүн нь сурагчид гэрийн даалгавар, дасгал хийхдээ бие даан хийж чаддаг ($M=4.38$), багшийн болон бусдын яриаг анхааралтай сонсож чаддаг ($M=4.36$) болох нь харагдаж байна. Харин уншсан номын утга, санаа, үг зэргийг бичиж авах байдал ($M=3.09$), суралцах явцад бусад сурагчдаас тусламж авах ($M=3.26$) үйлийн дундаж үзүүлэлт хамгийн бага ба дээрх үйлийг төдийлөн хийдэггүй болохыг харж байна.

Түлхүүр үг

Эх, санаа бодол, асуулт тавих, хянах, бие даан хийх

Удиртгал

Боловсрол Судлалын сургуулийн Боловсролын Судал Арга зүйн тэнхимийн судалгааны тэргүүлэх чиглэл болох “Суралцахуй ба багшлахуйн”

©2021 Author(s)



This article is published under the
Creative Commons CC-BY License by 4.0

хүрээнд ЕБС-ийн дунд ангийн сурагчдын сурах аргыг судалж мэдээллийн сантай болох ажлын хүрээнд бид 6-р ангиас эхлэн судалгааг хийж эхэлсэн. Их, дээд сургуульд элсэн суралцдаг оюутнуудын сурах арга шаардлага хангахгүй байна. Тухайн номын эх уншиж, утгыг өөрийн үгээр ярих, дүгнэлт хийх, асуулт тавих зэрэг сурах аргууд анхаарал татах болсон. Тус өгүүлэлд 6-р ангийн сурагчдын сурах ерөнхий 19 үйлийн төлөв байдлыг судалж, үнэлгээ дүгнэлт хийхийг зорилго болгосон.

Сурагчдын сурах ерөнхий аргын талаар гадаадын болон манай орны судлаачид 1970-аад оны үеэс судалгаа хийж эхэлсэн. Тухайлбал, эрдэмтэн судлаач Б. Бор (Бор, Б, 1974, pp. 10-14), (Бор, Б, 1986, pp. 55-82), А. Загдаа (Загдаа, А, 1987, pp. 50-54), (Загдаа, А., Мягмар, Ш., Монхор, Д., 1991) С. Нэргүй (Нэргүй, 1987, p. 40; 1987, p. 57). Я. Цэдэнбал нар (Цэдэнбал Я., 1987) , З.Бадамсамбуу (Бадамсамбуу, 1982, хууд. 65), Бардан, К.В (Бардин, 1989, хууд. 283), Д. Брунер (Брунер, 1977) сурах ерөнхий аргын талаар судалгаа хийж, өгүүлэл, ном бичсэн. Эдгээр судлаач сурах ерөнхий аргад ямар үйл багтаан үзсэнийг дараах table 1-ээр харуулья.

Table 1
Researchers' View on General Learning Skills

№	Судлаачийн нэр	Сурах ерөнхий аргад багтсан үйлүүд /сурах ерөнхий аргын агуулга
1	Б.Бор	...унших, бичих, ...
2	А.Загдаа	...номтой ажиллах, унших, тэмдэглэл хөтлөх
3	С.Нэргүй	...номтой ажиллах, унших, бичих ...
4	Я.Цэдэнбал нар	Материалын гол зүйлийг олох, дүгнэлт хийх, унших, бичих, тэмдэглэл хийх ...

1980-1990-ээд оны хугацаанд сурах аргын талаар манайд олон өгүүлэл, ном гарсан түүхтэй. Өнөө үед бид сурах аргыг цааш хөгжүүлж, бодитоор сайжруулахын тулд өнөөгийн сургалтын практикт сурах арга ямар байгааг судалж тогтоох шаардлага гарч ирсэн. Сурах аргыг тус өгүүлэлд бид дараах утгаар ойлгон хэрэглэж байгаа. Тухайлбал, сурах арга бол сурагч ... өөртөө хэрэгтэй мэдээ, мэдээллийг олж авч өөрийн болгон эзэмших, шинэ ойлголт /мэдлэг/ бүтээх үйл үйлдлүүд гэж Ш.Ичинхорлоо тодорхойлсон байна (Ичинхорлоо, Ш, 2019, хууд. 69). Сурах арга яагаад чухал вэ? Мэдээллийн эрин үед сургалтаар сурагчдад бүх мэдээллийг өгөх боломж үндсэндээ байхгүй болж, гаднын судлаачид бүх шатны сургалтын үндсэн зорилт бол сурагч өөрт хэрэгтэй мэдээллийг өөрөө олж авах аргыг эзэмшиж авах явдал хэмээн 1980-аад оны төгсгөл үеэс ярьж бичих болсон. Мөн хүн насан туршдаа суралцахын суурь нь сурагч байх үедээ сурах арга барилтай болох явдал боллоо. Сүүлийн үед хувь хүн амжилтад хүрэх гол нөхцөл бол сурагч байх үеэсээ амжилттай сурах арга барилтай болох явдал хэмээн үзэх боллоо. Сурах аргын талаар хийсэн суурь судалгааг үндэслэн түүнийг 1/ оюун ухааны үйл ажиллагааны арга барил /төслийн явцад үүнийг бид “оюун ухааны үйл” хэмээн нэрлэсэн, 2/ сурах үйл ажиллагаагаа төлөвлөн зохион байгуулах аргууд /төслийн явцад энэ аргыг бид “сурахуйгаа төлөвлөх үйлүүд” гэж нэрлэсэн, 3/ сурах ерөнхий аргууд,

4/ мэдээллийн эх үүсвэрийг ашиглах аргууд, 5/ тусгай аргууд хэмээн ангилсан (Ичинхорлоо, 1996).

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааг хот хөдөөгийн нийт 13 сургуулийн 1026 сурагчаас сурах үйлийн 19 асуулт бүхий асуумжаар танхим болон онлайн хэлбэрээр судалгааг зохион байгуулсан. Сурагчдаас авсан асуулгын асуултууд нь VI ангийн сурагчдаар сурах ерөнхий 19 үйлийн өөрийн үнэлгээ хийлгэхэд чиглэсэн бөгөөд лакертын 5 үетэй хариулт ба (1- үгүй, 2- бараг үгүй, 3-заримдаа, 4- ихэнхдээ, 5- байнга) гэсэн сонголтоор авсан. Судалгаанд хамрагдсан сурагчдын хувьд 452 (44.1%) нь эрэгтэй, 574 (55.9%) нь эмэгтэй ба Нийслэл хотын 744(72.5%), орон нутгийн 282(27.5%) байна. Судалгааны үр дүнг SPSS-23 программ дээр судалгааны асуултын хүчинтэй байдлын фактор шинжилгээ болон найдвартай байдлын шинжилгээг хийж боловсруулсан. Статистик боловсруулалтыг тойм статистик, дунджийн тухай таамаглал шалгах Т шинжүүр аргуудаар хийсэн.

Эдгээр үйл нь сурагчдын цаашдын сурахуй, ажил амьдралд байнга хэрэглэгдэх үйлүүд. 19 асуултыг задалбал VI ангийн сурагчдын ном уншихтай холбоотой 4 үйл /1-4-р асуулт/, ярихтай холбоотой 3 үйл /5-7-р асуулт/, дүгнэлт хийхтэй холбоотой 1 үйл /8-р асуулт/, асуулт асуух үйлтэй холбоотой нэг үйл /9-р асуулт/, шинэ санаа дэвшүүлэхтэй холбоотой 1 үйл /10-р асуулт/, шинэ үгийн утгыг тайлбарлахтай холбоотой 1 үйл /11-р асуулт/, мэдлэгээ ашиглахтай холбоотой 1 үйл /12-р асуулт/, сурагч мэдлэгээ өөрөө хянахтай холбоотой 2 үйл /13, 14-р асуулт/, дасгал даалгаврыг бие даан хийхтэй холбоотой 1 үйл /15-р асуулт/, бусдад туслах ба бусдаас тусламж авахтай холбоотой 2 үйл /16, 17-р асуулт/, сурагчийн зан байдалтай холбоотой 2 үйл /18, 19-р асуулт/ байв. Сурагч амжилттай сурах, үүнд тэрээр сурах ерөнхий үйлүүдийг хийх нь тэдний хүмүүжил, төлөвшилтэй холбоотой учраас эдгээр олон зүйлээс бид 4 үйлийг сонгон авч, сүүлийн 16-19-р асуулт болгон оруулсан. Асуултын хариултыг лакертын 5 үетэй хариулт ба (1- үгүй, 2- бараг үгүй, 3-заримдаа, 4- ихэнхдээ, 5- байнга) гэсэн сонголтоор авсан.

Судалгааны үр дүн

Судалгааны асуултын хүчинтэй байдлын фактор шинжилгээгээр сурах үйлийн 19 асуултыг гурван(Уншихтай холбоотой үйлүүд ($\alpha=0.622$), ерөнхий үйлүүд ($\alpha=0.817$), төлөвшилтэй холбоотой үйлүүд ($\alpha=0.536$), бүлэгт хувааж, бүлэг тус бүрийн болон найдвартай байдлын шинжилгээг хийхэд асуултууд бүгд өндөр нийцэлтэй Cronbach Alpha ($\alpha=0.864$) байсан ба эндээс бидний судалгааны асуултууд VI ангийн сурагчдын сурах үйлийн төлөвийг тодорхойлоход ашиглаж болох нь статистикийн хувьд батлагдаж байгааг доорх table 2-оос харж болно.

Table 2
Results of the Questionnaire on the Assessment of Students' Learning Abilities

Сурах үйлийг тодорхойлох асуултууд	Дундаж	Стандарт хазайлт	Cronbach's Alpha (α)
1. Ном уншаад, түүнээс өөртөө хэрэгтэй зүйл олж авч чаддаг уу?	3.86	.956	.622
2. Уншсан номын утгыг өөрийн үгээр бусдад ярьж өгч чаддаг уу?	3.57	1.154	
3. Уншсан номын утгыг эргэцүүлэн бодож чаддаг уу?	3.93	.981	
4. Чи уншсан номын утга, санаа, үг зэргийг бичиж авдаг уу?	3.09	1.361	
5. Чи өөрийн санаа, бодлыг бусад хүмүүст ойлгомжтой ярьж чаддаг уу?	3.56	1.165	.817
6. Чи бусдын яриаг анхааралтай сонсож чаддаг уу?	4.36	.851	
7. Чи бусдын ярианаас гол санааг олж чаддаг уу?	3.94	.958	
8. Сонссон, уншсан зүйлдээ дүгнэлт хийж чаддаг уу?	3.78	1.025	
9. Чи бусдаас ямар нэг зүйл асууж чаддаг уу?	4.16	1.049	
10. Ямар нэг зүйлийн талаар чи шинэ санаа, шийдэл дэвшүүлж чаддаг уу?	3.62	1.120	
11. Шинэ үгийн утгыг чи өөрийн үгээр тайлбарлаж чаддаг уу?	3.47	1.160	
12. Хичээл дээр олж мэдсэн зүйлээ амьдралдаа ашиглаж байсан уу?	3.77	1.123	
13. Чи мэдлэг чадвараа өөрөө хянаж, юуг шинээр олж мэдсэн эсэхээ олж чаддаг уу?	3.79	1.029	
14. Чи мэдлэг чадвараа өөрөө хянаж, ямар алдаа дутагдал байгааг олж чаддаг уу?	3.82	1.065	
15. Чи дасгал, даалгаврыг бие даан хийж чаддаг уу?	4.38	.803	.536
16. Чи суралцах явцад бусад сурагчдад тусалж байсан уу?	4.01	.970	
17. Чи суралцах явцад бусад сурагчдаас тусламж авч үзсэн үү?	3.26	1.075	
18. Чи өөрийн зан байдал, харилцаанд буй сайн зүйлээ олж чаддаг уу?	3.88	.966	
19. Чи өөрийн зан байдал, харилцаанд буй болохгүй зүйлээ олж чаддаг уу?	3.76	1.068	.923
KMO and Bartlett's Test			
Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.			
	Approx. Chi-Square	4761.369	
Bartlett's Test of Sphericity	df	171	0.000
	p утга		
Cronbach's Alpha (19 асуултын хувьд)			.864

Энэ үр дүнгээс харахад сурагчид гэрийн даалгавар, дасгал хийхдээ бие даан хийж чаддаг ($M=4.38$), багийн болон бусдын яриаг анхааралтай сонсож чаддаг ($M=4.36$) болох нь харагдаж байна. Харин уншсан номын утга, санаа, үг зэргийг бичиж авах байдал ($M=3.09$), суралцах явцад бусад сурагчдаас тусламж авах ($M=3.26$) үйлийн дундаж үзүүлэлт хамгийн бага ба дээрх үйлийг төдийлөн хийдэггүй болохыг харж байна.

Мөн VI ангийн суралцагчдын сурах үйлийн төлөвийг хүйсийн хувьд нь судалж үзэхэд дараах үр дүн харагдаж байна.

Table 3

Results of the Study on the Learning Abilities of Students by Gender

Сурах үйлийн төлөвийн асуулт	Хүйс	Сурагчид	Дундаж	Стандарт хазайлт	t	p
1. Ном уншаад, түүнээс өөртөө хэрэгтэй зүйл олж авч чаддаг уу?	Эр Эм	452 574	3.71 3.97	.988 .914	-4.502	.000
2. Уншсан номын утгыг өөрийн үгээр бусдад ярьж өгч чаддаг уу?	Эр Эм	452 574	3.43 3.68	1.186 1.116	-3.475	.001
3. Уншсан номын утгыг эргэцүүлэн бодож чаддаг уу?	Эр Эм	452 574	3.86 3.99	1.036 .933	-2.193	.029
4. Чи уншсан номын утга, санаа, үг зэргийг бичиж авдаг уу?	Эр Эм	452 574	2.96 3.20	1.411 1.311	-2.822	.005
5. Чи өөрийн санаа, бодлыг бусад хүмүүст ойлгомжтой ярьж чаддаг уу?	Эр Эм	452 574	3.56 3.55	1.166 1.165	.210	.834
6. Чи бусдын яриаг анхааралтай сонсож чаддаг уу?	Эр Эм	452 574	4.26 4.43	.877 .824	-3.250	.001
7. Чи бусдын ярианаас гол санааг олж чаддаг уу?	Эр Эм	452 574	3.90 3.98	.999 .924	-1.241	.215
8. Сонссон, уншсан зүйлдээ дүгнэлт хийж чаддаг уу?	Эр Эм	452 574	3.73 3.82	1.078 .981	-1.281	.201
9. Чи бусдаас ямар нэг зүйл асууж чаддаг уу?	Эр Эм	452 574	4.21 4.11	1.006 1.080	1.591	.112
10. Ямар нэг зүйлийн талаар чи шинэ санаа, шийдэл дэвшүүлж чаддаг уу?	Эр Эм	452 574	3.57 3.66	1.164 1.084	-1.334	.183
11. Шинэ үгийн утгыг чи өөрийн үгээр тайлбарлаж чаддаг уу?	Эр Эм	452 574	3.42 3.51	1.160 1.160	-1.222	.222
12. Хичээл дээр олж мэдсэн зүйлээ амьдралдаа ашиглаж байсан уу?	Эр Эм	452 574	3.67 3.85	1.174 1.077	-2.514	.012
13. Чи мэдлэг чадвараа өөрөө хянаж, юуг шинээр олж мэдсэн эсэхээ олж чаддаг уу?	Эр Эм	452 574	3.74 3.83	1.078 .988	-1.431	.153
14. Чи мэдлэг чадвараа өөрөө хянаж, ямар алдаа дутагдал байгааг олж чаддаг уу?	Эр Эм	452 574	3.71 3.90	1.131 1.004	-2.853	.004
15. Чи дасгал, даалгаврыг бие даан хийж чаддаг уу?	Эр Эм	452 574	4.35 4.40	.848 .766	-1.169	.243
16. Чи суралцах явцад бусад сурагчдад тусалж байсан уу?	Эр Эм	452 574	3.95 4.06	1.034 .915	-1.864	.063
17. Чи суралцах явцад бусад сурагчдаас тусламж авч үзсэн үү?	Эр Эм	452 574	3.23 3.29	1.080 1.071	-.823	.411
18. Чи өөрийн зан байдал, харилцаанд буй сайн зүйлээ олж чаддаг уу?	Эр Эм	452 574	3.77 3.97	1.018 .914	-3.391	.001
19. Чи өөрийн зан байдал, харилцаанд буй болохгүй зүйлээ олж чаддаг уу?	Эр Эм	452 574	3.73 3.78	1.096 1.046	-.731	.465

 $p < .05$

Дээрх үр дүнгээс харахад ном уншаад түүнээс өөртөө хэрэгтэй зүйл олж авч чаддаг, уншсан номын утгыг өөрийн үгээр бусдад ярьж өгч чаддаг, уншсан номын утгыг эргэцүүлэн бодож чаддаг, уншсан номын утга, санаа, үг зэргийг бичиж авдаг, бусдын яриаг анхааралтай сонсож чаддаг, хичээл дээр олж мэдсэн зүйлээ амьдралдаа ашигладаг, мэдлэг чадвараа өөрөө хянаж, ямар алдаа дутагдал

байгааг олж чаддаг, суралцах явцад бусад сурагчдад тусалдаг, өөрийн зан байдал, харилцаанд буй сайн зүйлээ олж чаддаг зэрэг үйлүүдийн хувьд охидын дундаж үзүүлэлт хөвгүүдийн дунджаас илүү ба статистикийн хувьд ялгаатай болохыг харсан. Харин бусад үйлийн тухайд хүйсийн ялгаа ажиглагдаагүй.

Мөн нийслэл болон орон нутагт суралцаж буй суралцагчдын хувьд ялгаа байгааг судалж үзэхэд дараах үр дүн гарсан.

Table 4

Results of the Study on the Learning Abilities of Students by Location

Судалгааны асуултууд	Харьяалал	Сурагчид	Дундаж	Стандарт хазайлт	t	p
1. Ном уншаад, түүнээс өөртөө хэрэгтэй зүйл олж авч чаддаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	3.87 3.83	.953 .965	.535	.592
2. Уншсан номын утгыг өөрийн үгээр бусдад ярьж өгч чаддаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	3.62 3.43	1.155 1.140	2.367	.018
3. Уншсан номын утгыг эргэцүүлэн бодож чаддаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	3.97 3.82	.946 1.063	2.268	.024
4. Чи уншсан номын утга, санаа, үг зэргийг бичиж авдаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	3.00 3.34	1.352 1.354	-3.612	.000
5. Чи өөрийн санаа, бодлыг бусад хүмүүст ойлгомжтой ярьж чаддаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	3.56 3.54	1.155 1.193	.340	.734
6. Чи бусдын яриаг анхааралтай сонсож чаддаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	4.33 4.43	.877 .776	-1.700	.089
7. Чи бусдын ярианаас гол санааг олж чаддаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	3.95 3.93	.938 1.008	.389	.697
8. Сонссон, уншсан зүйлдээ дүгнэлт хийж чаддаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	3.79 3.76	1.009 1.070	.420	.675
9. Чи бусдаас ямар нэг зүйл асууж чаддаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	4.17 4.11	1.025 1.109	.865	.387
10. Ямар нэг зүйлийн талаар чи шинэ санаа, шийдэл дэвшүүлж чаддаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	3.68 3.46	1.091 1.181	2.853	.004
11. Шинэ үгийн утгыг чи өөрийн үгээр тайлбарлаж чаддаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	3.49 3.44	1.145 1.201	.654	.513
12. Хичээл дээр олж мэдсэн зүйлээ амьдралдаа ашиглаж байсан уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	3.82 3.65	1.097 1.184	2.135	.033
13. Чи мэдлэг чадвараа өөрөө хянаж, юуг шинээр олж мэдсэн эсэхээ олж чаддаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	3.76 3.86	1.025 1.037	-1.336	.182
14. Чи мэдлэг чадвараа өөрөө хянаж, ямар алдаа дутагдал байгааг олж чаддаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	3.81 3.83	1.020 1.180	-.307	.759
15. Чи дасгал, даалгаврыг бие даан хийж чаддаг уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	4.38 4.37	.780 .864	.230	.818
16. Чи суралцах явцад бусад сурагчдад тусалж байсан уу?	Улаанбаатар Орон нутаг	744 282	4.06 3.89	.943 1.031	2.426	.015
	Улаанбаатар	744	3.26	1.090	-.217	.828

17. Чи суралцах явцад бусад сурагчдаас тусламж авч үзсэн үү?	Орон нутаг	282	3.27	1.037		
18. Чи өөрийн зан байдал, харилцаанд буй сайн зүйлээ олж чаддаг уу?	Улаанбаатар	744	3.91	.924		
	Орон нутаг	282	3.80	1.066	1.681	.093
19. Чи өөрийн зан байдал, харилцаанд буй болохгүй зүйлээ олж чаддаг уу?	Улаанбаатар	744	3.77	1.045		
	Орон нутаг	282	3.72	1.129	.590	.555

$p < .05$

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад уншсан номын утгыг өөрийн үгээр бусдад ярьж өгч чаддаг, уншсан номын утгыг эргэцүүлэн бодож чаддаг, ямар нэг зүйлийн талаар шинэ санаа, шийдэл дэвшүүлж чаддаг, хичээл дээр олж мэдсэн зүйлээ амьдралдаа ашигладаг, суралцах явцад бусад сурагчдад тусалдаг, өөрийн зан байдал, харилцаанд буй сайн зүйлээ олж чаддаг зэрэг үйлийн хувьд нийслэл хотын сурагчид, орон нутгийн сурагчдаас дундаж үзүүлэлтээр өндөр харин уншсан номын утга, санаа, үг зэргийг бичиж авдаг, бусдын яриаг анхааралтай сонсож чаддаг зэрэг үйлийн хувьд орон нутгийн сурагчдын дундаж үзүүлэлт өндөр байна. Харин бусад үйлийн хувьд төдийлөн ялгаа үзэгдсэнгүй. Өөрөөр хэлбэл хөдөө орон нутгийн суралцагчид интроверт буюу дотогшоо чиглэсэн, Улаанбаатар хотын суралцагчид илүү нээлттэй, бие даасан, экстрроверт буюу гадагшаа чиглэсэн болохыг харж болохоор байна.

VI ангийн сурагчдын ном уншихтай холбоотой 4 үйлийн үр дүнг дүгнэвэл гурван сурагчийн хоёр нь ном уншаад хэрэгтэй зүйл олж авдаг, нэг нь үгүй гэсэн үг. Гурван сурагчийн нэг нь уншсан номоо бусдад ярьж өгдөг, хоёр нь үгүй байна. Гурван сурагчийн хоёр нь уншсан зүйлээ боддог ба нэг нь үгүй байна. Таван сурагчийн хоёр нь тэмдэглэл хийдэг, үлдсэн гурван сурагч үгүй бололтой. Таван сурагчийн нэг нь ном уншихтай холбоотой 4 үйлийг байнга хийдэг, нэг сурагч ихэнхдээ хийдэг, нэг сурагч заримдаа хийдэг, хоёр сурагч үгүй байгаа нь 5 сурагчийн 3 нь номтой холбоотой 4 үйлийг хийдэг, 2 нь үгүй гэж үзэх үндэстэй.

VI ангийн сурагчдын сурах ерөнхий 11 үйлийн хувьд дүгнээд үзэхэд хоёр сурагчийн нэг нь санаа бодлоо бусдад ойлгомжтой ярьж чаддаг, нэг нь үгүй байна. Хоёр сурагчийн нэг бусдын яриаг анхааралтай сонсдог, нэг сурагч үгүй байна. Гурван сурагчийн хоёр нь бусдын ярианаас гол санааг олж авдаг, үлдсэн нэг сурагч үгүй байна. Таван сурагчийн гурав нь сонссон, уншсан зүйлдээ дүгнэлт хийдэг, үлдсэн хоёр нь үгүй гэж үзэж болох байна. Дөрвөн сурагчийн гурав нь бусдаас юм асуудаг, нэг нь үгүй байгаа явдал бол боломжийн үзүүлэлт гэж үзэж болох байна. Таван сурагчийн гурав нь шинэ санаа дэвшүүлдэг, хоёр нь үгүй байна. Хоёр сурагчийн нэг шинэ үгийг утгыг тайлбарладаг гэж өөрсдийгөө үзэж байгаа бол нөгөө нэг сурагч үгүй байна. Гурван сурагчийн хоёр мэдлэгээ амьдралдаа хэрэглэдэг бол нэг нь үгүй байна. Таван сурагчийн гурав нь мэдлэг чадвараа хянаж, шинээр олж мэдсэн зүйлээ ухаарч ойлгодог, үлдсэн хоёр нь үгүй байна. Таван сурагчийн гурав нь алдаа дутагдлаа олж хардаг, хоёр нь үгүй байна. Таван сурагчийн дөрөв нь дасгал даалгаврыг бие даан хийдэг, нэг нь үгүй байна. Гурван

сурагчийн хувьд сурах 11 үйлийг хийж чаддаг ба нэг сурагч үгүй гэсэн дүгнэлт хийх боломжтой байна.

VI ангийн сурагчдын төлөвшилтэй холбоотой үйлийн судалгаанд анализ хийж үзэхэд дөрвөн сурагчийн гурав нь бусад сурагчдад тусалдаг нь сайн үзүүлэлт бөгөөд үлдсэн нэг сурагч үгүйг бид цаашид анхаарах зүйлийн нэг юм. Таван сурагчийн гурав нь бусад сурагчдаас тусламж авч үзээгүй буюу бие дааж дасгал даалгавраа хийхийг урьтал болгодог бол үлдсэн хоёр сурагч бусад сурагчдаас тусламж авч үзсэн байна. Гурван сурагчийн хоёр нь өөрийн давуу талаа олж хардаг ба үлдсэн нэг сурагч үгүй болохыг харж болохоор байна. Мөн таван сурагчийн гурав нь өөрийн зан байдал, харилцаанд буй болохгүй зүйлээ олж хардаг, үлдсэн хоёр сурагч үгүй байна. Эдгээр хоёр сурагчид өөрийн болохгүй зүйлээ олж харахад багш нар, эцэг эхчүүд болон найз нарын туслалцаа хэрэгтэй. Эцэст нь 6-р ангийн сурагчдын төлөвшилд эерэг зүйл байгааг харууллаа. Тухайлбал, сурагчдын 60.6% нь бусдад тусалдаг, бусдаас тусламж авдаг, өөрийн зан байдал, харилцаанд буй сайн, болохгүй зүйлээ олж хардаг байна. Сурагчдын 39.4% ийм чадвар үгүй байгаад багш нар, эцэг эхчүүд болон сурагч өөрөө анхаарч, төлөвшүүлэх хэрэгтэй болно.

Дүгнэлт

Их, дээд сургуулийн оюутны сурах арга шаардлага хангахгүй байгаа нь тэд ЕБС-д суралцаж байх үедээ сурах ерөнхий үйлийг буюу аргыг хангалттай сайн эзэмшээгүйтэй холбоотой болов уу гэсэн бидний урьдчилсан үзэл энэхүү судалгаагаар батлагдсан.

Дээрх байдал нь сурагчид их, дээд сургуульд мэдээллийн олон төрлийн эх сурвалж ашиглахад саад болохоос гадна тэд ажлын байранд гараад мэдээлэл боловсруулах, ашиглах чадварт сөргөөр нөлөөлөх талтай.

Судалгаанаас үзвэл 6-р ангийн 5 сурагчийн 3 нь уншихтай холбоотой үйлийг гүйцэтгэдэг, 2 нь үгүй гэдэг бол сайн үр дүн биш /үр дүн 60%-тай/. Мөн сурах 11 үйлийн хувьд 3 сурагчийн 2 нь эдгээр үйлийг ямар нэг байдлаар гүйцэтгэдэг бол 1 сурагч эдгээр үйлийг хийдэггүй гэдэг бол бидний хүлээж буй үр дүн мөн л биш /үр дүн 77%-тай/. Өөрөөр хэлбэл сурагчдын 33%-40% нь сурах ерөнхий аргыг эзэмшээгүй байдал нь бид бүхний заавал анхааран сайжруулах зүйл мөн.

Иймд сурагчдад бага, дунд ангид суралцаж байх үед нь сурах ерөнхий аргыг сайн эзэмшүүлэх явдал сургалтын нэг гол зорилт болох ёстой.

ЕБС-ийн 6-р ангийн эрэгтэй сурагчдын сурахуйд нийт багш нар илүү анхаарч ажиллах шаардлага байна.

Хөдөө орон нутгийн сурагчдын сурах аргад онцгойлон анхаарах хэрэгцээ бий болсон.

Тус өгүүлэлд өгүүлсэн сурах ерөнхий 19 үйл нь нэг талаасаа сурах ерөнхий арга боловч том утгаараа харилцааны соёл, боловсролын чанар, амьдралын чанар зэрэгтэй салшгүй холбоотой зүйл.

Төгсгөлд нь бага, дунд ангийн бүх мэргэжлийн багш нарын сургах аргыг сайжруулж, үүнд сурагчдад мэдлэг эзэмшүүлэх гэхээс илүү сурагч бүрд бие дааж сурах ерөнхий аргыг сайн эзэмшүүлэх чиглэлээр тэдэнд онолын мэдлэг, практик туслалцаа үзүүлэх хэрэгтэй байна.

Судалгааны хязгаарлагдмал тал

Тус судалгаанд 2020 онд зөвхөн VI ангийн сурагчид хамрагдсан. Дараагийн жилүүдэд бид системтэй судалгаа хийж, VII, VIII, IX ангийн сурагчдыг шат дараатай хамруулан судална.

Корона вирусийн цар тахлын хөл хорионы улмаас бид төлөвлөсөн бусад аймгийн VI ангийн сурагчдыг уг судалгаанд хамруулж чадаагүй.

Уг судалгааны хүрээнд бид VI ангийн сурагчдын оюун ухааны үйл, төлөвлөн зохион байгуулах үйл, мэдээллийн эх сурвалжийг ашиглах үйл зэргийг судалсан бөгөөд эдгээрийн үр дүнг өөр өгүүлэлд тусган, бусад сэтгүүлүүдэд хэвлүүлсэн болно.

Талархал

ЕБС-ийн VI ангийн суралцагчдын суралцах үйл ямар байгааг тодруулах зорилгоор хот хөдөөгийн нийт 13 сургуулийн 1026 сурагчдаас 19 асуулгаар танхим болон онлайн хэлбэрээр зохион байгуулахад багийн зохион байгуулалтаар хамтран ажилласан тус судалгааны багийн гишүүд дэд профессор Р. Намжилдагва, багш П.Алтанцэцэг, багш докторант Б.Ононтуул, Д.Базарваань болон Боловсрол судлаач ангийн 4 дүгээр курсийн оюутнууддаа талархал илэрхийлье.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Бадамсамбуу, З. (1982). Сурах арга барилыг сурагчдаар эзэмшүүлэх тухай. *Сурган хүмүүжүүлэгч сэтгүүл*, № 4, х.65
- Бардин, К. В. (1989). *Как научить детей учиться*. Москва: Издательство Педагогика р. 283
- Бор, Б. (1974). *Суралцах аргын тухай сурагчдад өгүүлэх нь*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар
- Бор, Б. (1986). *Суралцах арга барил эзэмшүүлэх нь*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар х 96-99
- Брунер, Д. (1977). *Психология познания*. Москва : Изд-во Педагогика
- Загдаа, А. (1987). Сурагчдад сурах арга барил эзэмшүүлэх нь. *Сурган хүмүүжүүлэгч сэтгүүл*, № 5, х. 50- 54
- Загдаа, А. М. (1991). *Ерөнхий эрдмийн хичээлээр сурагчдад сурах арга барил эзэмшүүлэх*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар
- Ичинхорлоо, Ш. (1996). *Сурагчдад мэдээллийн эх үүсвэрээс бие дааж суралцах арга эзэмшүүлэх арга зам. докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл*
- Ичинхорлоо, Ш. (2019). *Сурахуй хийгээд сурах арга*. Улаанбаатар: Алмаз пресс
- Нэргүй, С. (1987). Сурагчдад сурах арга эзэмшүүлэх нь. *Сурган хүмүүжүүлэгч сэтгүүл*, №1, тал 40
- Нэргүй, С. Р. (1987). Сурах арга эзэмшүүлэх нь орчин үеийн шаардлага мөн. *Сурган хүмүүжүүлэгч сэтгүүл*, №1, х. 57
- Цэдэнбал Я., Э. Б. (1987). *Сурах аргын тухай сурагчдад өгүүлэх нь*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар

The Study on 19 Learning Activities of The Sixth-Grade Secondary School Students

Ichinkhorloo Shagjjav, Munkhtsetseg Narantsetseg*

Department of educational studies and methodology, School of educational studies,
Mongolian National of Education, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: munkhtsetseg.n@msue.edu.mn

Received:4/9/2021

Revised:7/21/2021

Accepted:12/15/2021

Abstract

The study aims to illuminate the level of the learning abilities of the 6th grade secondary schools students. A total of 1026 sixth-grade students from 13 secondary schools of Ulaanbaatar (the capital city), Selenge, Khentii, and Tuv Provinces participated in this study. The questionnaire was focused on assessing students' learning skills and evaluate their learning abilities by 19 activities. To collect data, the questionnaire was designed with a five-point Likert scale consisting of 1 ("not at all"), 2 ("a little bit"), 3 ("sometimes"), 4 ("often"), and 5 ("always"). The participants consisted of 452 male students (44.1%) and 574 female students (55.9%), whereas 744 students (72.5%) were from schools of the capital city and 282 students (27.5%) from schools of rural areas. To analyze the validity factors and the study reliability, the SPSS Version 23 statistical program was used for data analysis and such research methods as the descriptive statistics and t-tests were applied. The study results demonstrate that students do their homework without any help ($M=4.38$) and listen to others ($M=4.36$). This illustrates that the students' self-learning skills show higher mean score. On the other hand, the mean score of the students' learning ability of making notes about the general idea of books they read ($M=3.09$) and getting some help from others ($M=3.26$) show the least mean score. This reveals that students do not do such activities at all. The study concludes that 87.16% of total 1026 students can conduct 19 active learning activities whereas 12.84% of students do not do such activities.

Keywords

Text, mind, question, control, independent study
